



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-д
эрх бүхий албан тушаалтан томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр Нацаг овогтой Амарбаярыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг Н.Амарбаярт үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000563